

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АСУУДЛААР ИРҮҮЛСЭН ИРГЭДИЙН ӨРГӨДЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2014.06.17.

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд эрүүл мэндийн салбарын асуудлаар 2013 онд 197, 2014 он гарсаар 107 иргэнээс өргөдөл ирүүлсэн байна.

Иргэдийн өргөдлийг Байнгын хорооны 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн ажиллах чиг үүргийн хуваарь, өргөдөл шийдвэрлэх журам”-ын дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Сарангэрэл нар судлан Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Тус Байнгын хороонд ирүүлсэн нийт өргөдлийн 50 хувийг хөдөлмөрийн насны иргэд, 25 хувийг хүүхэд, 15 хувийг тэтгэврийн насны ахмадууд, 10 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өргөдөл эзэлж байна. Мөн өргөдлийн дийлэнх хувь нь эмчлүүлэхэд өрхийн орлого нь хүрэлцэхгүй байгаа, гадаадад эмчлүүлэх шаардлагатай болсон тухай өргөдөл байна.

Иргэдээс 2013-2014 онд тус Байнгын хороонд болон Улсын Их Хурлын гишүүдэд ирүүлсэн “эмчилгээний зардал хүрэлцэхгүйгээс санхүүгийн тусламж хүсэх” тухай өргөдөлд хариу өгөхдөө тухайн гишүүний саналыг тусган, Улсын Их Хурлын тухай хуулийн 37.1.1-д “ногдсон төсвийг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах,” 37.1.4-д “ гишүүний нэр хүнд, эрх мэдлийг ашиглан ..., бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах,” 37.1.7-д “хууль бус шийдвэр гаргуулахаар бусдад нөлөөлөх; 37.1.8-д “ гишүүний бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох, шахалт үзүүлэх;” -ийг гишүүнд хориглоно гэж тус тус заасныг үндэслэн тайлбар, зөвлөгөө өгөх, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд албан бичгээр уламжлах, иргэнд бичгээр зөвлөмж хүргүүлэх зэргээр шийдвэрлэсэн байна.

Эмчилгээний зардлын асуудлын Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулахаас гадна Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 313 дугаар тушаалаар баталсан “Зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам”-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын тушаалаар иргэдийн эмчилгээний зардлын 5 хувийг тусламж болгон олгож байна. Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.6, 13.5.7-д байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд, 16-аас дээш насны иргэнд улиралд нэг удаа Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор тэтгэмж олгохоор заасан байна.

Мөн иргэдийн ирүүлсэн саналын шинжтэй өргөдөлд дараах асуудлуудыг хөндсөн байна:

- Хүн амын дунд хорт хавдар, мэдрэлийн систем, цус, дархлаа, үе мөч, ясны өвчлөл ихэссэн, иргэдийн эрүүл мэндийн даатгалын системийн тогтолцоо учир дутагдалтай,
- Иргэд хаана хэрхэн хандаж эрүүл мэндээ хамгаалуулах, урьдчилан сэргийлэх тал дээр мэдээлэл дутмаг, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй,

- Улсын эмнэлгүүд өндөр ачаалалтай, хүнд сурталтай, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, 50 хувийг хувьчлах хэрэгтэй,
- Монгол Улсад орж ирж байгаа эм, эмнэлгийн бүтээгдэхүүнүүд олон улсын чанарын шаардлагад нийцсэн эсэх нь тодорхойгүй, чанаргүй, хуурамч бүтээгдэхүүнүүд их байна,
- Хувийн эмнэлгүүд дураараа өндөр үнэтэй үйлчилгээ үзүүлдэг, чанар муутай баталгаагүй эмчилгээ хийж байна,
- Гадаадад эмчлүүлэх өвчний жагсаалтад ороогүй хүнд хэлбэрт шилжсэн өвчтэй иргэд ялангуяа хүүхдүүдэд хандсан тусламж үйлчилгээ, дэмжлэг шаардлагатай,
- Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчтөн гадаад улсад эмчлүүлэх тохиолдолд улсаас олгох эмчилгээний зардлын хувь хэмжээ бага, чирэгдэл ихтэй байдаг,
- Зарим өвчинг дотооддоо эмчлэгдэх боломжтой ч төлбөр өндөр, зохицуулалт дутмаг байна,
- Хяналт тавьж ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын мэдээлэл дутмаг, хяналтыг сайжруулах хэрэгтэй байна гэх мэт.

Иймд 2014 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 7/4240 тоот албан бичгийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, дараах асуудлаар Байнгын хороонд мэдээлэл хийлгэхээр бэлтгүүлсэн. Үүнд:

1. Хүн амын өвчлөлийн байдал, ялангуяа хавдрын өвчлөл нэмэгдэж байгаа шалтгаан түүнийг бууруулах талаар ямар бодлого баримталж буй,
2. Эмнэлгийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар авч буй арга хэмжээ,
3. Эрүүл мэндийн үйлчилгээний үнэ тариф, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ,
4. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах талаар авч буй арга хэмжээ,
5. Эрүүл мэндийн салбарын хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр авч буй арга хэмжээ.

Түүнчлэн 2014 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 7/4241 тоот албан бичгээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хандсанаар эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээ, тулгамдаж буй асуудлын талаарх саналыг ирүүлсэн байна.

Санал, дүгнэлт

Иргэдээс ирүүлсэн өргөдлүүдэд шинжилгээ хийж үзэхэд эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог шинэчлэн сайжруулах талаар төрөөс дорвитой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Иймд Байнгын хорооны гишүүдийн саналыг тусган Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар,
Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл